

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САЙНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8
3	Менежментийн захидал .....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.5	Төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчллийн жагсаалт.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/282  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол төрийн түүхийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдалд, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол төрийн түүхийн музейн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын үр дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол төрийн түүхийн музейн захирал Н.Оюунтэгш Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол төрийн түүхийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 15-наас 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өлзийт экаунт аудит ХХК-ын аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өлзийт экаунт аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн X/66 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

## Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол төрийн түүхийн музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол төрийн түүхийн музей нь “Төрийн түүхэнд холбогдох дурсгалыг цуглуулж, хадгалан хамгаалах, судлан шинжлэх, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх, монгол төрийн түүхэн хөгжил, залгамж шинжийг сурталчлан нийгмийн ухамсарт нөлөөж төлөвшүүлэх” нь гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 30 дугаар тогтоолоор Монгол төрийн түүхийн музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн түүхэнд холбогдох дурсгалыг цуглуулж, хадгалан хамгаалах, судлан шинжлэх, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх.
- Монгол төрийн түүхэн хөгжил, залгамж шинжийг сурталчлан нийгмийн ухамсарт нөлөөлж төлөвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Монгол төрийн түүхийн музейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол төрийн түүхийн музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Музейн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монгол төрийн түүхийн музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив” програм хангамж ашигладаг байна.

Монгол төрийн түүхийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад санхүүгийн дотоод хяналт нь үр нөлөөтэй ажилласан гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Монгол төрийн түүхийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгээр сонгоход материаллаг түвшин өндөр, мөн өөрийн орлогогүй улсын төсвөөр санхүүждэг зэргээс шалтгаалж төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгосон.

## Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг ажил гүйлгээний цар хүрээ бага боловч эрсдэлтэй гэж үзээд үр дүнгийн тайлангийн зардлын дүн 217,838.8 мянган төгрөгийг суурь үзүүлэлтээр авч, 1 хувиар буюу 2,771.9 мянган төгрөгөөр тогтоож баталгаажуулав.

Аудитын ажлын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын холбогдолтой асуудал үүсээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 16 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 14 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/ Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1,320.0	
	Дүн	1	1,320.0	

#### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгийн орлогыг 200,0 мянган төгрөгөөр илүү бүртгэснийг залруулав.

Шийдвэрлэсэн нь: Алдааг залруулсан

### 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас шилжүүлэн өгсөн компьютерыг үнэ тодорхойгүйгээс үндсэн хөрөнгийн орлогод бүртгэлгүй хойшлуулсныг дараагийн аудитаар анхааран авч үзнэ үү.

### 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

## Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол төрийн түүхийн музейн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой арга хэмжээнд зориулан 2018 онд 276,600.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 261,263.1 мянган төгрөг буюу 94.5 хувиар төсвөө зарцуулж үлдэгдэл 14,837.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Монгол төрийн түүхийн музейн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. 2018 онд тус байгууллага бүтэн жилээр оруулах мэдээнээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэргийг хугацаандаа оруулж худалдан авах үйл ажиллагааны тайлан мэдээг хоцроож оруулсан байна. Тухай бүр оруулах мэдээнээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тухай 3 мэдээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлийн дагуу 1 мэдээг хугацаандаа оруулж ажилласан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол төрийн түүхийн музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь үзүүлэв. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### 1.1 Илрүүлэлт:

Тайлант онд батлагдсан урсгал засварын зардлаас 1,320.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан нь толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

##### 1.2 Эрсдэл:

Зардлыг ангиллын дагуу зориулалтаар зарцуулж бүртгэхгүй байх.

##### 1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын дагуу төсвийг зориулалтаар нь зарцуулах.

##### 1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зориулалтаар нь зарцуулна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>69,115,788.50</u></b>	<b><u>123,403,555.87</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>477,502.00</b>	<b>977,502.00</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>477,502.00</b>	<b>977,502.00</b>
31110	Төгрөг	477,502.00	977,502.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>6,197,400.00</b>	<b>50,507,305.87</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>6,197,400.00</b>	<b>50,507,305.87</b>
3351	Байгууллагаас авах авлага	6,197,400.00	50,507,305.87
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>5,485,768.00</b>	<b>8,214,968.00</b>
34200	Төсөвт байгууллага	5,485,768.00	8,214,968.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>56,955,118.50</b>	<b>63,703,780.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>56,955,118.50</b>	<b>63,703,780.00</b>
35410	Бичиг хэргийн материал	8,762,125.50	8,025,077.00
35420	Аж ахуйн материал	39,518,415.00	42,571,065.00
35430	Сэлбэг хэрэгсэл	795,300.00	1,510,300.00
35440	Түлш, шатах тослох материал	665,800.00	796,900.00
35470	Бусад хангамжийн материал	7,213,478.00	10,800,438.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>469,121,803.84</u></b>	<b><u>474,181,783.74</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>469,121,803.84</b>	<b>474,181,783.74</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>468,626,654.29</b>	<b>473,906,484.64</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,500,000.00	-6,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,146,774.75	48,141,774.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,717,194.60	-30,142,729.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,174,560.00	68,174,560.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55,783,238.19	-62,537,377.04
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	427,916,160.80	441,516,160.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	129,971,307.30	129,971,307.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-129,763,811.77	-129,971,307.30
39217	Ном	8,682,096.00	8,754,096.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>495,149.55</b>	<b>275,299.10</b>
39301	Програм хангамж	41,776,640.00	41,776,640.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-41,281,490.45	-41,501,340.90
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>538,237,592.34</u></b>	<b><u>597,585,339.61</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>538,237,592.34</u></b>	<b><u>597,585,339.61</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>538,237,592.34</b>	<b>597,585,339.61</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	742,060,566.40	742,060,566.40
51101	Өмч: - төрийн	742,060,566.40	742,060,566.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-208,099,240.46</b>	<b>-148,751,493.19</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-210,481,631.30	-208,099,240.46
51220	Тайлант үеийн үр дүн	2,382,390.84	59,347,747.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,276,266.40	4,276,266.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>538,237,592.34</u></b>	<b><u>597,585,339.61</u></b>

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>218,541,677.75</b>	<b>277,186,594.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,389,889.75</b>	<b>586,194.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>586,194.70</b>
120009	Бусад орлого	00.00	586,194.70
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,389,889.75</b>	<b>00.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	3,389,889.75	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>215,151,788.00</b>	<b>276,600,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>215,151,788.00</b>	<b>276,600,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	215,151,788.00	276,600,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>216,159,286.91</b>	<b>217,838,847.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>216,159,286.91</b>	<b>217,838,847.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>191,169,012.92</b>	<b>201,051,951.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>140,881,048.29</b>	<b>146,395,699.34</b>
210101	Үндсэн цалин	140,881,048.29	146,395,699.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,573,705.62</b>	<b>17,510,153.52</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,573,705.62	17,510,153.52
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,871,233.50</b>	<b>6,794,410.10</b>
210401	Бичиг хэрэг	1,944,978.00	2,490,048.50
210402	Тээвэр, шатахуун	1,411,900.00	1,423,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,355.50	456,451.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,424,770.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,975,457.00</b>	<b>669,968.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,154,817.00	210,000.00
210604	Урсгал засвар	2,820,640.00	459,968.00
2107	Томилолт, зочны зардал	1,974,400.00	240,000.00
210702	Дотоод албан томилолт	1,974,400.00	240,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,476,515.60</b>	<b>11,809,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	973,615.60	1,520,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,930,000.00	9,075,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,900.00	214,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,416,652.91</b>	<b>17,632,220.10</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,028,000.00	2,025,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,388,652.91	15,607,020.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,990,273.99</b>	<b>16,786,896.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,564,059.34</b>	<b>1,949,621.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,414,700.00	1,949,621.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,883,329.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	266,030.34	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,426,214.65</b>	<b>14,837,275.37</b>

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,426,214.65	14,837,275.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>2,382,390.84</u></b>	<b><u>59,347,747.27</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>2,382,390.84</u></b>	<b><u>59,347,747.27</u></b>

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>215,151,788.00</b>	<b>276,605,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>5,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>5,000.00</b>
120009	Бусад орлого		5,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>215,151,788.00</b>	<b>276,600,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>215,151,788.00</b>	<b>276,600,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	215,151,788.00	276,600,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>209,303,806.00</b>	<b>276,105,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>209,303,806.00</b>	<b>212,238,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>179,586,037.91</b>	<b>195,451,503.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>136,210,357.71</b>	<b>146,636,229.13</b>
210101	Үндсэн цалин	114,261,957.71	114,158,529.13
210102	Нэмэгдэл	6,081,500.00	16,610,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,866,900.00	15,866,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,793,399.55</b>	<b>17,793,334.90</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,793,399.55	17,793,334.90
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,004,577.50</b>	<b>3,946,421.60</b>
210401	Бичиг хэрэг	1,002,722.00	958,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,411,700.00	1,413,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	590,155.50	380,651.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,194,070.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,217,699.55</b>	<b>2,435,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,217,699.55	2,435,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,474,087.00</b>	<b>3,786,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,540,087.00	1,238,800.00
210604	Урсгал засвар	3,934,000.00	2,547,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,974,400.00</b>	<b>1,190,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,974,400.00	1,190,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,426,516.60</b>	<b>18,974,118.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	973,616.60	5,504,118.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,880,000.00	11,880,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,900.00	590,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,485,000.00</b>	<b>690,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,485,000.00	690,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,717,768.09</b>	<b>16,786,896.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,291,553.44</b>	<b>1,949,621.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,771,497.90	1,949,621.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,803,029.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,717,026.54	00.00

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,426,214.65</b>	<b>14,837,275.37</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,426,214.65	14,837,275.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>5,847,982.00</u></b>	<b><u>64,367,000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,624,480.00</b>	<b>63,867,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>5,624,480.00</b>	<b>63,867,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	5,624,480.00	63,867,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,624,480.00	-63,867,000.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>223,502.00</b>	<b>500,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>254,000.00</b>	<b>477,502.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>477,502.00</b>	<b>977,502.00</b>

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>-210,481,631.30</b>	<b>535,855,201.50</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>-210,481,631.30</b>	<b>535,855,201.50</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,382,390.84	<b>2,382,390.84</b>
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>-208,099,240.46</b>	<b>538,237,592.34</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>-208,099,240.46</b>	<b>538,237,592.34</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00		00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	59,347,747.27	<b>59,347,747.27</b>
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>742,060,566.40</b>	<b>4,276,266.40</b>	<b>-148,751,493.19</b>	<b>597,585,339.61</b>

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		477,502.00	-477,502.00	0.0
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>276,600,400.00</b>	<b>261,263,124.63</b>	<b>15,337,275.37</b>	<b>94.5</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>276,600,400.00</b>	<b>261,263,124.63</b>	<b>15,337,275.37</b>	<b>94.5</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>274,600,400.00</b>	<b>259,313,503.63</b>	<b>15,286,896.37</b>	<b>94.4</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>148,398,400.00</b>	<b>146,636,229.13</b>	<b>1,762,170.87</b>	<b>98.8</b>
210101	Үндсэн цалин	115,920,700.00	114,158,529.13	1,762,170.87	98.5
210102	Нэмэгдэл	16,610,800.00	16,610,800.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,866,900.00	15,866,900.00	-	100.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,807,800.00</b>	<b>17,793,334.90</b>	<b>14,465.10</b>	<b>99.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,807,800.00	17,793,334.90	14,465.10	99.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,279,900.00</b>	<b>4,018,421.60</b>	<b>261,478.40</b>	<b>93.9</b>
210401	Бичиг хэрэг	1,030,000.00	1,030,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,413,700.00	1,413,700.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	636,200.00	380,651.60	255,548.40	59.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,194,070.00	5,930.00	99.5
2105	<b>Нормативт зардал</b>	<b>2,435,400.00</b>	<b>2,435,000.00</b>	<b>400.00</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,435,400.00	2,435,000.00	400.00	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,170,900.00</b>	<b>10,781,400.00</b>	<b>389,500.00</b>	<b>96.5</b>
210601	Багаж. Техник. Хэрэгсэл	7,236,900.00	6,913,800.00	323,100.00	95.5
210604	Урсгал засвар	3,934,000.00	3,867,600.00	66,400.00	98.3
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,199,000.00</b>	<b>1,190,000.00</b>	<b>9,000.00</b>	<b>99.2</b>
210702	Дотоод албан томилолт	1,199,000.00	1,190,000.00	9,000.00	99.2
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>76,809,000.00</b>	<b>75,774,118.00</b>	<b>1,034,882.00</b>	<b>98.7</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,157,000.00	62,304,118.00	852,882.00	98.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	11,880,000.00	11,880,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182,000.00		182,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	590,000.00	590,000.00	-	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,500,000.00</b>	<b>685,000.00</b>	<b>11,815,000.00</b>	<b>5.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,500,000.00	685,000.00	11,815,000.00	5.5

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,000,000.00</b>	<b>1,949,621.00</b>	<b>50,379.00</b>	97.5
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>1,949,621.00</b>	<b>50,379.00</b>	97.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,949,621.00	<b>14,837,275.37</b>	97.5
	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>276,600,400.00</b>	<b>261,763,124.63</b>	<b>14,837,275.37</b>	
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>276,600,400.00</b>	<b>261,763,124.63</b>	<b>14,837,275.37</b>	94.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	276,600,400.00	261,763,124.63	14,837,275.37	94.6
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>477,502.00</b>	<b>-477,502.00</b>	0.0
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>977,502.00</b>	<b>-977,502.00</b>	0.0

Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Монгол төрийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</i>	Аудитын код:
2019 он			САГ-2019/167/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол төрийн түүхийн музей		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй. Урсгал засварын зардлын данснаас хөрөнгө бэлтгэсэн	1,320.0	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Н.Оюунтэгш, Д.Цэцэгмаа
	<b>Дүн</b>	<b>1,320.0</b>			

